

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА

*Д.Батхүү - Хууль сахиулахын удирдлагын акедамын
8042 дугаар дамжааны суралцагч. хошууч*

*В.Пүрэвбаасан -Хууль сахиулахын удирдлагын
акедамын Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн дэд профессор, хурандаа*

ХИЛИЙН ОТРЯДЫН АР ТАЛ ХАНГАЛТЫН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТИЙН ОНОЛЫН ҮНДЭС

Хураангуй: Энэхүү нийтлэлээр ар тал хангалтын удирдлага, төлөвлөлтийн онолын асуудал болон өнөөгийн байдалд тулгамдаж буй зарим асуудлыг дэвшүүлсэн болно.

Түлхүүр үг: Цэргийн ар тал, удирдлага, төлөвлөлт, тавигдах шаардлага

Улс орон тусгаар тогтносон, бүрэн эрхт улс байх гол шалгууруудын нэг нь өөрийн гэсэн газар нутаг, хил хязгаартай, тэдгээр нь халдашгүй дархан байх явдал билээ.

Монгол Улсын төрөөс улсын хилийн хамгаалалтын эрх зүйн болон бусад хангалтад байнга анхаарч ирсний үр дүнд улсын хилийн хамгаалалтын хүчин чадал бэхжиж, хил хамгаалах байгууллага үүргээ зохих түвшинд гүйцэтгэж байна. Гэвч сүүлийн жилүүдэд хилийн цагийн байдал өөрчлөгдөн хил дамнасан гэмт хэрэг, хар тамхи мансууруулах бодис, хүний наймааны бүлэг зохион байгуулалтанд орж манай орны нийгэмд аюул занал учруулах бодит үзэгдэл болж байна¹. Энэ нөхцөл байдлаас үүдэн хүч хэрэгслийн нягтрал, бүлэглэлийг нэмэгдүүлж, тэдгээрт тохирсон хил хамгаалалтын ар тал хангалтын удирдлагын нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөлтийн хувилбаруудыг боловсруулах, асуудал урган гарч байна.

Нэг. Хилийн отрядын ар тал хангалтын удирдлага

Ар талын удирдлага нь хилийн отрядын улсын хил хамгаалах үндсэн үүргийг биелүүлэх, цаг ямагт байнга бэлэн байх, бэлэн байдлыг хангах, Хилийн цагийн байдлаас үндэслэн шинээр тавигдсан үүрэг даалгаврыг биелүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор ар талын албадын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаа юм.²

¹ Улсын хилийн аюулгүй байдал ба хамтын ажиллагаа., УБ.2012, 121. дахь тал

²Лхагва Б. Хилийн цэргийн ар тал хангалтын зарим асуудал. УБ., 2005. 45. дахь тал.

Хил хамгаалалтын ар тал хангалтын онол нь анги, салбаруудын ар тал болон тэдгээрийг удирдах нэгжийг байршуулах орчин үеийн техник хэрэгслээр хангах, шилжүүлэн байрлуулах тухай шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, ар талыг удирдах байгууллага, салбарын ар талын бие бүрэлдэхүүнд онолын мэдлэг олгох, ар талыг удирдах, торөл бүрийн зориулалттай ар талын салбаруудын тусгай үүрэг гүйцэтгэхэд шаардагдах практик чадварыг олгоход чиглэсэн аргачлал, зөвлөмжийг боловсруулах, хилийн цэрэгт хэмнэлтэт, оператив цэргийн хэрэгслийн нөөцийг тогтоох, тэдгээрийг хил хамгаалах чиглэл. хэсэгт байрлуулах, цуваажилт, нөөцлөх, хадгалах, ар талыг хамгаалах талаар зөвлөмж боловсруулахад нэн шаардлагатай онолын үндэслэлийг бий болгож өгдөг¹.

Ар тал хангалтын онолын нэг гол асуудал бол хилийн цэргийн ар талын орон тоо, зохион байгуулалтыг бэхжүүлэхэд оршино. Үүний тулд ар талыг удирдах салбар нэгжүүд, мэргэжлийн албан тушаалтнуудийг бэлтгэн нийлүүлж, томилдог байх явдал юм.

Хилийн цэргийн ар талын хангалтын удирдлагын тогтолцоо нь хангалтыг зохион байгуулагч бие бүрэлдэхүүн, хангалтын анги салбар гэсэн объект ба ар талын хангалтын удирдлага гэсэн субъектээс бүрдэж байна.

Ар талын хангалтын удирдлагын субъект нь ар талын бие бүрэлдэхүүний 20 хувиас хэтрэхгүй байхаар зохион байгуулагдах нь зүйтэй.

Хилийн отрядын ар талын удирдлагад дараах арга хэмжээнүүд хамаарна гэж үздэг. Үүнд:

- Хангалтыг зохион байгуулах шийдвэрээ гаргана.
- Захирагдагсаддаа үүрэг хүргэнэ.
- Хилийн отряд, түүний салбаруудын хил хамгаалалт, үйл ажиллагааны ар талын хангалтыг төлөвлөнө.
- Зэргэлдээ ангиудын ар талын албад, ар талын анги, салбаруудтай харилцан ажиллагааг зохион байгуулна.
- Хилийн отрядын байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэхтэй холбогдолтой ар талын хангалтын чиглэлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- Ар талын удирдлагын системийг зохион байгуулна.
- Онцгой нөхцөл байдал үүссэн үед хилийн отрядын ар талын хангалтыг зохион байгуулах бэлтгэлийг хангах зэрэг үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлдэг. Үүнээс хилийн отряд, түүний салбаруудын ар талын хангалтыг төлөвлөх асуудлыг авч үзэх нь чухал юм².

¹ Лхагва Б.Хилийн цэргийн ар тал хангалт, үйлчилгээ олон талтай УБ., 2003, дахь тал.

² Лхагва Б. Ар тал хангалтын онолын зарим асуудал.УБ., 2005. 65 дахь тал.

Ар тал хангалтын удирдлагын зарчмууд: Улсын хил хамгаалалтын ар талын хангалтыг зохион байгуулах, түүнийг төлөвлөн удирдахдаа цэргийн удирдлагын нийтлэг зарчимд тулгуурладаг.

Хоёр. Хилийн отрядын ар тал хангалтын төлөвлөлтийн үндэс

Аливаа төлөвлөлт нь байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд нийт арга замыг олон хувилбараар боловсруулж, түүнээс аль оновчтойг нь сонгох ажиллагаа юм¹. Төлөвлөлтийн үндсэн дээр байгууллагын онөөгийн нөхцөл байдал, зорилт, түүнийг хэрэгжүүлэх арга замууд тодорхойлогдоно.

Төлөвлөлт² гэдэг нь нөхцөл байдлын шинжилгээний үндсэн дээр тодорхойлогдсон зорилго ба уг зорилгод хүрэх арга хэмжээнүүдийн нэгдлийг хэлнэ. Төлөвлөлтийг дараах дөрвөн шалтгааны улмаас хийдэг байна:

- Тодорхой бус байдлыг багасгах;
- Зорилтыг нарийн тодруулан гаргаж ирэх;
- Үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах;
- Хяналт шалгалт хийхэд хялбар болгох зорилгоор.

Төлөвлөлтийг хүсэж сонирхсон дурын зүйлээсээ эхлэн хийдэггүй тодорхой дараалал, зарчмыг баримталдаг бөгөөд дараах үе шаттай байна:

- Нөхцөл байдлыг шинжлэх
- Зорилго ба төлөвлөгөөний хувилбаруудыг боловсруулах
- Зорилго ба төлөвлөгөөг үнэлэх
- Зорилго ба төлөвлөгөөг сонгох
- Төлөвлөгөөг хэрэгжүүлэх
- Төлөвлөгөөг хянах ба дүгнэх.

Нөхцөл байдлыг шинжлэхдээ хугацаа ба нөөц хязгаарлагдмал учраас төлөвлөгөө зохиогч төлөвлөлттэй холбоотой бүх мэдээллийг цуглуулах ба нэгтгэх шаардлагатай. Мөн түүнчлэн өнгөрсөн тохиолдлыг судалж, одоогийн нөхцөл байдлыг шалган нягтлаад ирээдүйн хандлагыг таамаглахыг хичээх ёстой. Нөхцөл байдлыг шинжлэхдээ ихэвчлэн гадаад эх үүсвэрээс мэдээлэл цуглуулахаас гадна байгууллагын дотоод дахь бүх хэсгүүдээс мэдээлэл цуглуулдаг. Энэхүү алхамын үр дүн нь төлөвлөгөөний төслийг судлах ба харьцуулах явдал юм.

Хилийн анги, отрядын ар талын хангалтын үйл ажиллагаа нь цаг тухайдаа тодорхой төлөвлөгдсөн байх бөгөөд энэ нь ангийн захирагч, штаб болон орлогчдоос ар талын хангалтыг зохион байгуулж удирдах үндэс болно. ^{1 2}

¹ Цэрэндорж Ц. Бидний менежмент. УБ., 2010. 45 дахь тал.

² Төлөвлөлт нь удирдлагын нэг үндсэн функц бөгөөд тухайн байгууллагын зорилго, түүнд яаж хүрэхийг тодорхойлох менежментийн үйл ажиллагааны хэсэг юм.

Толовлөлт гэдэг нь: Цэргийг анги салбаруудын тавигдсан үүргээс нь хамаарч аливаа үйл ажиллагаанд удирдах, бэлэн байдлыг хангаж бэлэн байдлын зэргүүдэд шилжихэд бэлэн байх хангалт үйлчилгээг цаг хугацаанд нь бүрэн зохион байгуулах, ажлыг захирагч, штабаас авах дэс дараалсан арга хэмжээг урьдчилан харж тогтоох арга ажиллагаа юм. Ар тал хангалт үйлчилгээний толовлөлтийг бүх шатанд шинжлэх ухааны үндэслэлтэй, эдийн засгийн тооцоонд тулгуурлан хууль тогтоомж норм, нормативын хүрээнд зөв хийж хэвшүүлэх шаардлагатай.

Анги, отрядын аж ахуй үйл ажиллагааны толовлөлтийн үндсэн зорилго:

1. Бие бүрэлдэхүүний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлснээр алба-байлдааны бэлэн байдлыг ямагт өндөр байлгах зорилгоор хангалтын зохион байгуулах, гүйцэтгэх дараалал, ажлын ачаалал, хэмжээг шинжлэх ухааны үндэстэйгээр тодорхойлох;

2. Хамгийн бага зардал гаргаж, хамгийн дээд амжилтанд хүрэхээр хангалтыг үр ашигтайгаар зохион байгуулах;

3. Мөнгөн хөрөнгө, материалыг зориулалтаар зөв, арвилан хэмнэлттэй зарцуулах, тэдгээрийг хамгаалах;

4. Материал хэрэгсэл, зэвсэглэл байлдааны ба бусад техникийг зөв хадгалах, эзэмших, ашиглах ажиллагааг зохион байгуулах;

5. Мөнгө хөрөнгө, материал хэрэгслийг зориулалтаар нь зарцуулахаас хамаарч төрөл мэргэжлийн албадын чиглэлээр хийж гүйцэтгэх аж ахуйн ажлыг зохицуулах;

6. Анги, отрядын хэмжээнд зайлшгүй хийх шаардлагатай аж ахуйн үйл ажиллагааг зөв тодорхойлж түүнд шаардлагатай хөрөнгө, материал хэрэгслийг цаг тухайд нь бэлтгэн авах бололцоог олгох;¹²

Ар талын хангалтын үйл ажиллагааны толовлөлтийн үндэс нь бэлэн байдлын толовлөгөө, дарга (захирагч)-ийн заавар чиглэл мөн бөгөөд дараах зүйлийг удирдлага болгоно:

- Анги, отрядын орон тоо, табель, төсөв, хангалтын нормууд, улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулж удирдан явуулах тухай удирдамж

Хил хамгаалах ерөнхий газрын үндсэн арга хэмжээний толовлөгөөний товч хуулбар

- Анги, отрядын материал хэрэгслээр хангагдсан болон орон сууцны фондын байдал

- Улсаас олгогдсон төсөв, түүний хүрэлцээ, зарцуулах журам

¹ Лхагва Б. Ар тал хангалтын удирдлага, толовлөлт. УБ., 2006., 56 дахь тал.

² Лхагва Б. Ар тал хангалтын онолын зарим асуудал. УБ., 2005. 38 дахь тал.

- Дотоодын хяналт шалгалт болон (аудитын) дээд байгууллагаас хийсэн шалгалтын нотломжууд

- Салбар (застав)-ын захирагч, албадын дарга нарын саналуудыг судална.

Хилийн ангиудад ар талын хангалтын үйл ажиллагааны төлөвлөлтийн дараах бичиг баримтууд үйлдэгдэнэ.¹ Үүнд:

1. Ахуй хангалтын жилийн төлөвлөгөө
2. Зэвсэглэл, байлдааны ба бусад техникийн засварын жил, сарын төлөвлөгөө
3. Ачаа-тээврийн жилийн ба сарын төлөвлөгөө
4. Арвилан хэмнэлтийн жилийн төлөвлөгөө
5. Албадын сарын ажлын төлөвлөгөө
6. Засварын газрын сарын төлөвлөгөө /авто, хувцас, тоног хэрэгслэл, барилга/
7. Туслах аж ахуйг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө
8. Парк аж ахуйн өдөрлөгийн төлөвлөгөө
9. Хяналт шалгалтын жилийн төлөвлөгөө
10. Тусгай арга хэмжээнүүдийг хангах төлөвлөгөө

Ахуйн хангалтын жилийн ажлын төлөвлөгөө нь ахуйн үйл ажиллагааны төлөвлөлтийн үндэс баримт бичиг бөгөөд 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэл хугацаагаар боловсруулна. Ахуйн хангалтын жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах явцыг 2 үед хуваан ойлгож болно.

-Бэлтгэл ажлын үе (10 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 15)

-Боловсруулалтын үе (11 сарын 15-наас 12 дугаар сарын 20)

Ахуйн хангалтын жилийн төлөвлөгөөнд албаны бэлэн байдлыг хангах, бие бүрэлдэхүүний материаллаг болон соёлын хэрэгцээг хангахтай холбогдсон үйл ажиллагааны бүх ажлууд тусгагдана. Уг төлөвлөгөө нь дор дурдсан үндсэн бүлгээс бүрдэнэ. Үүнд:

1. Ар талын хангалтын ерөнхий асуудлууд, төлөвлөлт, хяналт, шалгалт
2. Шатахуун тосолгооны материалын албаны арга хэмжээ
3. Хүнсний албаны арга хэмжээ
4. Хувцасны албаны арга хэмжээ

Хилийн цэргийн ар талын хангалтын төлөвлөлтийг боловсруулах болон хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хамаарч гурван үндсэн хүрээнд авч үзнэ. Үүнд:

- 1 .Стратегийн төлөвлөлт
- 2 .Тактикийн /удирдлагын /төлөвлөлт

¹ Лхагва Б. Ар тал хангалтын онолын зарим асуудал. УБ., 2005. 46 дахь тал.

3. Үйл ажиллагааны /үйлдлийн/ төлөвлөлт гэж ангилна.

Үйл ажиллагааны төлөвлөлтийг:

- 1 Ар талын хангалтын бизнес төлөвлөгөө
- 2 Ар талын хангалтын жилийн ажлын төлөвлөгөө
- 3 Улирал, сарын ажлын төлөвлөгөө
- 4 Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө
- 5 Аривлан хэмнэлтийн төлөвлөгөө
- 6 Тусгай арга хэмжээний төлөвлөгөө гэж ангилж болно.

Хилийн отрядын аривлан хэмнэлтийн төлөвлөгөөнд тусгагдах зүйл.

- 1 Бие бүрэлдэхүүнийг хэмнэх үзлээр хүмүүжүүлэх
- 2 Байлдааны болон хүн нэг бүрийн зэвсэг техникийн ашиглалтын үр дүнг дээшлүүлэх
- 3 Бүх төрлийн зэвсэг техник ,материал хэрэгслийг аривлан хэмнэх, хайрлан хамгаалах ажиллагаанд бие бүрэлдэхүүнийг сургах
- 4 Материал хэрэгслийн бүрэн бүтэн байдал, түүний бүртгэл тооцооны байдалд байнга хяналт тавих
- 5 Материал хэрэгслийг хайрлан хамгаалах талаар шинэ бүтээл оновчтой санал санаачлагыг хөгжүүлэн дэмжих
- 6 Сургалтын материаллаг баазыг боловсронгуй болгох
- 7 Туслах аж ахуй мал аж ахуйг идэвхтэй хөгжүүлэх
- 8 Байгаль экологи, газар тариалан, жимс жимсгэний аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх.

Дүгнэлт

Хилийн цэргийн ар талын үр дүн нь улс эх орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, Улсын хилийн баталгаажилт, хил хамгаалалтын үр дүнгээр байнга илрэн гарч байдаг зүй тогтолтой бөгөөд энэ нь төрөөс зохицуулалтыг байнга шаардаж байдаг. Хил хамгаалалтын урлагийн хөгжлийн явц нь хилийн цэргийн ар тал, зэвсэг техник, материал хэрэгслийн хангалтын тоо, чанар, хангалтын байдал орчин үеийн техник технологийн шинэчлэлтээс гадна хүний хөгжил, мэдлэг чадвараас ихээхэн хамааралтай.

1. Хил хамгаалах байгууллага нь 2006 оноос эхлэн хилийн цэргийн дээд сургуульд ар талын мэргэжлтэнгүүдийг анх бэлтгэн ирсэн ба өнөөдрийн байдлаар хилийн отрядуудын ар талын удирдлага болон салбар нэгжүүдийн хүн эмнэлэг, хөдөө аж ахуй, санхүүгийн албаны бүрэлдэхүүнд мэргэжлийн сургууль болох Хөдөө аж ахуйн их сургууль, Ангаах ухааны их сургууль, Санхүүгийн сургууль төгссөн хүний нөөцийг томилон ажилуулж байна. Харин бусад албан тушаал болох хүнсний алба. барилга орон сууц, шатахуун.

хувцас. зэвсгийн албанд янз бүрийн албан тушаалтан томилогдож байгаа нь учир дутагдалтай юм.

Дэвшүүлэх санал

1. Хил хамгаалах байгууллага бодлогын түвшинд хилийн отряд ангиудын ар талын удирдлага болон салбар нэгжүүдэд байгаа албан тушаалд хилийн сургуулийн ар талын мэргэжлтэнгээр төгссөн боловсон хүчинг томилж ажилуулах, тэдний залгамж чанарыг алдагдуулахгүй байхад анхаарах.

2. Хилийн отряд салбар нэгжүүдэд ажиллаж байгаа ар талын албадын албан тушаалтангуудын давтан сургалт, мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар тасралтгүй явуулж байх.

3. Ар талын хангалт үйлчилгээний төлөвлөлтийг бүх шатанд шинжлэх ухааны үндэслэлтэй, эдийн засгийн тооцоонд тулгуурлан хил хамгаалах байгууллага бодлогоор хийж байгаа боловч хилийн отрядууд ямар нэг асуудлуудыг өөрсдийн дотоод нөөц бололцоогоор шийдвэрлэж байгаа нь ойрын 2, 3 жилийн асуудлыг шийдвэрлээд цаашдын хэтийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй байдал ажиглагдаж байна.

С.Баттулга -Хууль сахиулахын удирдлагын академийн
8021 дүгээр дамжааны суралцагч, хошууч
В.Пүрэвбаасан -Хилийн албаны удирдлага стратегийн
профессорын багийн дэд профессор, хурандаа

БҮСЧИЛСЭН ХИЛ ХАМГААЛАЛТАНД АР ТАЛ МАТЕРИАЛ ХЭРЭГСЛИЙН ХАНГАЛТЫН ОЙЛГОЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Хураангуй: Бүсчилсэн хил хамгаалалтанд ар тал материал хэрэгслийн хангалтыг зохион байгуулаж буй үндэслэл, үйл ажиллагаа өнөөгийн байдалд дүн ишнэжилгээ хийж, цаашид анхаарах зарим асуудлын талаар хөндөхийг хичээлээ.

Түлхүүр үг: Ар тал, хангалт, үйлчилгээ, өнөөгийн байдал.

Ар тал хангалтын ерөнхий ойлголт: Бүсчилсэн хил хамгаалалтыг зохион байгуулан хэрэгжүүлэхэд зайлшгүй харгалзвал зохих чухал хүчин зүйлийн нэг нь бүх төрлийн хангалт, түүний дотор ар талын буюу материал хэрэгслийн хангалт юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулан тодорхойлох үндсэн нутаг дэвсгэр нь бүс нутгууд буюу говь цөл, уул, тал хээр, ой тайгын бүсүүд бөгөөд эдгээр бүсүүд дахь зах зээлийн харилцаа. орон